



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/662

Булган сум

Хяналт шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 222, 2024 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хишиг-Өндөр суманд уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Корал майнинг инвестмент” ХХК ашиглалтын үйл ажиллагаа явуулсан эсэх, “Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто зам” барих зориулалтаар ашигласан карьеруудад хийх хяналт шалгалтыг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн дотор зохион байгуулсугай.

2. Хяналт, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх ажилд шаардагдах зардал, машин техникээр хангахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

4. Хяналт шалгалтын ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, ажиллахын ажлын хэсэг (Г.Давааням)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010929

Сугар Ажил 2025 өдөр бүр Дос/2025/Захирамж

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 20 ны/ний өдрийн
А/662 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ХАМТАРСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ

- Ажлын хэсгийн ахлагч: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга)
- Гишүүд: Т.Наранцацралт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн Геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч)
- С.Сүхбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн Авто замын хяналтын улсын байцаагч)
- С.Амар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
- Э.Манлайбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажилтан)
- Б.Шинэсайхан (Хангал сумын Сум дундын цагдаагийн тасгийн Экологийн асуудал хариуцсан байцаагч, Цагдаагийн дэслэгч)
- М.Хос-Эрдэнэ (Байгаль орчны газрын Байгаль орчны улсын хяналтын байцаагч мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: С.Алтанзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 20-ны ний өдрийн
А/662-дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ,
УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН КАРЬЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ**

1.Зорилго

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд шалгалтын зорилго оршино.

2.Удирдлага болгох хууль тогтоомж

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Эрүүгийн хууль
- Зөрчлийн тухай
- Газрын тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоол, 2014 оны 222 дугаар тогтоол

3.Шалгалтын хугацаа, арга хэлбэр

Ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн дотор Хишиг-Өндөр суманд ашигт малтмал хайх, олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Корал майнинг инвестмент ХХК, “Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто зам”-ын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайд хууль, журмын дагуу ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийнэ.

4.Шалгах зүйлс.

5.1.Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь заалтуудын хэрэгжилтийг шалгах /Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ХХК -д/

5.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт, Засгийн газрын 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим, төсөл хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын хэрэгжилтийг шалгах (замын компанид)

5.Дүнгийн талаар

Шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.

6.Хяналт шалгалт хийх маршрут

д/д	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа /өдөр/	Тоо хэмжээ /л/	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	2	3	4	5	6	7
1	Булган - Хишиг-Өндөр	200	1	36	3330	119880
2	Хишиг-Өндөр -Булган	200	1	36	3330	119880
Дүн						239760

Тайлбар: Ажлын хэсэг Аймгийн Засаг даргын тамгын газрын Starex машинаар явна. Албан хаагчдын томилолтын зардлыг тухайн байгууллага нь хариуцна.